



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2023/136-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум

2023 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040      Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036      Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК

Утас: 99102291      Цахим хаяг: [Nitsbalance@gmail.com](mailto:Nitsbalance@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-19
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17-18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗД	Засаг дарга
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэлийн
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН 2 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Ж. БҮРЭНБУЯН ТАНАА

2023.02.25 № СЭА-2023/136-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.0 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 1,561.3 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,356.9 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 2,924.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, батлагдсан төсвийг 1.0 хувиар хэмнэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 72.0 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх

нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 11.3 хувийг нормативт зардал, 8.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>40,832,054.00</b>	<b>53,486,959.60</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		<b>6,643,205.60</b>
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		6,643,205.60
3121	Төгрөг		6,643,205.60
31211	Төрийн сангийн харилцах		6,643,205.60
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>40,832,054.00</b>	<b>46,843,754.00</b>
351	Түүхий эд материал	2,669,398.00	2,698,898.00
3511	Тусгай зориулалттай материал	2,669,398.00	2,669,398.00
3513	Эм боох материал		29,500.00
354	<b>Хангамжийн материал</b>	<b>38,162,656.00</b>	<b>44,144,856.00</b>
3541	Бичиг хэргийн материал	2,575,451.00	2,575,451.00
3545	Барилгын засварын материал	799,200.00	799,200.00
3546	Хүнсний материал	636,400.00	1,536,000.00
3547	Бусад хангамжийн материал	34,151,605.00	39,234,205.00
II	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,549,928,220.04</b>	<b>1,526,626,405.81</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,549,928,220.04</b>	<b>1,526,626,405.81</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,454,604,469.98</b>	<b>1,431,707,655.75</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,414,166,879.00	1,414,166,879.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-62,353,966.92	-89,064,399.24
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,424,178.84	70,921,079.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-26,337,450.24	-26,082,383.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,585,794.94	23,345,516.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,286,251.68	-12,137,470.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,337,844.00	67,337,844.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,932,557.96	-16,779,410.64
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>95,323,750.06</b>	<b>94,918,750.06</b>
39301	Программ хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-656,249.94	-1,061,249.94
39303	Бусад биет бус хөрөнгө	94,330,000.00	94,330,000.00
III	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,590,760,274.04</b>	<b>1,580,113,365.41</b>
IV	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>6,896,595.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>6,896,595.00</b>
413	Өглөг		6,896,595.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		6,896,595.00
414	Урьдчилж орсон орлого		
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
422	Урт хугацаат зээл		
V	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,590,760,274.04</b>	<b>1,573,216,770.41</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,590,760,274.04	1,573,216,770.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	400,803,767.00	400,803,767.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		

511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн	400,803,767.00	400,803,767.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,027,513,442.60	1,009,969,938.97
5121	Өмнөх үеийн үр дүн	1,027,513,442.60	1,027,513,442.60
5122	Тайлант үеийн үр дүн		-17,543,503.63
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	162,443,064.44	162,443,064.44
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,590,760,274.04</b>	<b>1,580,113,365.41</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>516,504,442.61</b>	<b>2,290,435,121.48</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,545,517.84</b>	<b>1,608,110,454.50</b>
120	Нийтлэг татварын бус орлого	5,545,517.84	1,608,110,454.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,634,171.84	1,566,954,900.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	911,346.00	41,155,554.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>510,958,924.77</b>	<b>682,324,666.98</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	466,861,600.00	577,233,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		577,233,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	466,861,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>43,971,324.77</b>	<b>105,091,366.98</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,971,324.77	105,091,366.98
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>551,458,927.21</b>	<b>717,218,351.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>551,458,927.21</b>	<b>717,218,351.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>534,724,714.73</b>	<b>699,610,651.07</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>359,392,282.95</b>	<b>431,230,348.00</b>
210101	Үндсэн цалин	247,056,634.95	328,661,895.00
210102	Нэмэгдэл	96,708,367.00	89,334,494.00
210104	Урамшуулал	15,627,281.00	13,233,959.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>49,299,179.57</b>	<b>55,625,798.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,804,403.24	38,481,606.53
210202	Тэтгэмжийн даатгал	3,639,425.77	4,183,757.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,898,000.85	3,483,114.34
210204	Ажилгүйдлийн даатгал	722,824.31	860,703.99
210205	Эрүүл мэндийн даатгал	7,234,525.40	8,616,616.76

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,448,424.77</b>	<b>66,170,483.60</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,229,724.77	5,112,083.60
210302	Түлш, халаалт	33,947,400.00	33,947,700.00
210303	Цэвэр, бохир ус	6,271,300.00	27,110,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,919,150.00</b>	
210401	Бичиг хэрэг	739,100.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	761,245.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,892,991.00	
210408	Бараа материал ахталсны зардал	6,225,814.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,347,970.00</b>	<b>75,740,050.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	263,390.00	50,700.00
210502	Хоол, хүнс	23,084,580.00	75,689,350.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,293,360.00</b>	<b>7,816,000.00</b>
210604	Урсгал засвар	3,293,360.00	7,816,000.00
2107	Томилолт, зочны зардал	265,200.00	
210702	Дотоод албан томилолт	265,200.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,698,000.00</b>	<b>782,016.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	402,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		782,016.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,061,147.44</b>	<b>62,245,954.69</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,661,525.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	4,048,535.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,761,147.44	47,535,894.69
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,734,212.48</b>	<b>17,607,700.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг		17,607,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		17,607,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,734,212.48	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,734,212.48	
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-34,954,484.60</b>	<b>1,573,216,770.41</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		
<b>V</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-34,954,484.60</b>	<b>1,573,216,770.41</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>510,958,924.77</b>	<b>682,324,666.98</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>510,958,924.77</b>	<b>682,324,666.98</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	466,861,600.00	577,233,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		577,233,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	466,861,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	126,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>43,971,324.77</b>	<b>105,091,366.98</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,971,324.77	105,091,366.98
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>503,263,224.77</b>	<b>668,474,061.38</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>503,263,224.77</b>	<b>668,474,061.38</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>486,529,012.29</b>	<b>650,866,361.38</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>359,392,282.95</b>	<b>431,230,348.00</b>
210101	Үндсэн цалин	247,056,634.95	328,661,895.00
210102	Нэмэгдэл	96,708,367.00	89,334,494.00
210104	Урамшуулал	15,627,281.00	13,233,959.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>49,299,179.57</b>	<b>55,625,798.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,804,403.24	38,481,606.53
210202	Тэтгэмжийн даатгал	3,639,425.77	4,183,757.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,898,000.85	3,483,114.34
210204	Ажилгүйдлийн даатгал	722,824.31	860,703.99
210205	Эрүүл мэндийн даатгал	7,234,525.40	8,616,616.76
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>43,448,424.77</b>	<b>59,273,888.60</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,229,724.77	5,112,083.60
210302	Түлш, халаалт	33,947,400.00	33,947,700.00
210303	Цэвэр, бохир ус	6,271,300.00	20,214,105.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,310,245.00</b>	
210401	Бичиг хэрэг	1,369,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	761,245.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,880,000.00	
2105	<b>Нормативт зардал</b>	<b>23,522,320.00</b>	<b>76,588,950.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	263,390.00	
210502	Хоол, хүнс	23,258,930.00	76,588,950.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,293,360.00</b>	<b>7,816,000.00</b>

210604	Урсгал засвар	3,293,360.00	7,816,000.00
2107	Томилолт, зочны зардал	265,200.00	
210702	Дотоод албан томилолт	265,200.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,698,000.00</b>	<b>782,016.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	402,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		782,016.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,300,000.00</b>	<b>19,549,360.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		13,519,425.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	6,029,935.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,734,212.48</b>	<b>17,607,700.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг		17,607,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		17,607,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,734,212.48	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,734,212.48	
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>7,695,700.00</b>	<b>13,850,605.60</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>7,695,700.00</b>	<b>7,207,400.00</b>
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	7,695,700.00	7,207,400.00
	Дотоод эх үүсвэрээр	7,695,700.00	7,207,400.00
222001	Тоног төхөөрөмж	4,695,700.00	7,207,400.00
223001	Бусад хөрөнгө	3,000,000.00	
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-7,695,700.00</b>	<b>-7,207,400.00</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		<b>6,643,205.60</b>
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		<b>6,643,205.60</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/				
Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Д Ү Н
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>353,183,767.00</b>	<b>162,443,064.44</b>	<b>1,062,467,927.20</b>	<b>1,578,094,758.64</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	47,620,000.00			47,620,000.00
Тайлант үеийн үр дүн			-34,954,484.60	-34,954,484.60
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>400,803,767.00</b>	<b>162,443,064.44</b>	<b>1,027,513,442.60</b>	<b>1,590,760,274.04</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-1,590,760,274.04	-1,590,760,274.04
Тайлант үеийн үр дүн			1,573,216,770.41	1,573,216,770.41
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>400,803,767.00</b>	<b>162,443,064.44</b>	<b>1,009,969,938.97</b>	<b>1,573,216,770.41</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>682,324,900.00</b>	<b>675,681,461.38</b>	<b>6,643,438.62</b>	<b>99.0</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>682,324,900.00</b>	<b>675,681,461.38</b>	<b>6,643,438.62</b>	<b>99.0</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>664,717,200.00</b>	<b>658,073,761.38</b>	<b>6,643,438.62</b>	<b>99.0</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>432,791,700.00</b>	<b>431,230,348.00</b>	<b>1,561,352.00</b>	<b>99.6</b>
Үндсэн цалин	330,066,300.00	328,661,895.00	1,404,405.00	99.6
Нэмэгдэл	86,505,000.00	89,334,494.00	-2,829,494.00	103.3
Урамшуулал	16,220,400.00	13,233,959.00	2,986,441.00	81.6
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,982,700.00</b>	<b>55,625,798.78</b>	<b>1,356,901.22</b>	<b>97.6</b>
Тэтгэврийн даатгал	38,639,100.00	38,481,606.53	157,493.47	99.6
Тэтгэмжийн даатгал	4,513,500.00	4,183,757.16	329,742.84	92.7
ҮОМШӨ-ний даатгал	3,741,800.00	3,483,114.34	258,685.66	93.1
Ажилгүйдлийн даатгал	916,700.00	860,703.99	55,996.01	93.9
Эрүүл мэндийн даатгал	9,171,600.00	8,616,616.76	554,983.24	94.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>59,273,900.00</b>	<b>59,273,888.60</b>	<b>11.4</b>	<b>100</b>
Гэрэл, цахилгаан	6,621,900.00	5,112,083.60	1,509,816.40	77.2

Түлш, халаалт	29,367,300.00	33,947,700.00	-4,580,400.00	115.6
Цэвэр, бохир ус	23,284,700.00	20,214,105.00	3,070,595.00	86.8
<b>Нормативт зардал</b>	<b>79,512,900.00</b>	<b>76,588,950.00</b>	<b>2,923,950.00</b>	<b>96.3</b>
Хоол, хүнс	79,512,900.00	76,588,950.00	2,923,950.00	96.3
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,816,100.00</b>	<b>7,816,000.00</b>	<b>100</b>	<b>100</b>
Урсгал засвар	7,816,100.00	7,816,000.00	100	100
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,258,000.00</b>	<b>782,016.00</b>	<b>475,984.00</b>	<b>62.2</b>
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,258,000.00	782,016.00	475,984.00	62.2
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,081,900.00</b>	<b>26,756,760.00</b>	<b>325,140.00</b>	<b>98.8</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	27,081,900.00	26,756,760.00	325,140.00	98.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,030,000.00	6,029,935.00	65	100
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,607,700.00</b>	<b>17,607,700.00</b>		<b>100</b>
Бусад урсгал шилжүүлэг	17,607,700.00	17,607,700.00		100
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,607,700.00	17,607,700.00		100
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>682,324,900.00</b>	<b>682,324,666.98</b>	<b>233.02</b>	<b>100</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>577,233,300.00</b>	<b>577,233,300.00</b>		<b>100</b>
Улсын төсвөөс санхүүжих	577,233,300.00	577,233,300.00		100
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>105,091,600.00</b>	<b>105,091,366.98</b>	<b>233.02</b>	<b>100</b>
Орон нутгийн төсвөөс	105,091,600.00	105,091,366.98	233.02	100
Байгууллагын тоо	1	1		
Ажиллагсдын тоо	31	31		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	17	17		
Үйлчлэх ажилтан	13	13		
<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>				
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>6,643,205.60</b>	<b>-6,643,205.60</b>	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Мандал сумын 2 дугаар цэцэрлэг нь “Сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан хүүхэд бүрийг бүтээлч үйлээрээ хөгжих чадварт суралцахад бүх талууд хамтарч дэмжлэг үзүүлнэ” гэсэн эрхэм зорилго тавин ажиллажээ.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлжээ. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагаа гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн үед тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж цахим хичээл даалгаврын сантай болох;
- Эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх;
- Сургалтын үйл ажиллагааны чанарыг сайжруулах багш нарыг бүлгийн зохион байгуулалтаар хамтарч ажиллах мэргэжил арга зүйгээр дэмжин ажиллах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,

- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,646.9 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	6,643.2	6,643.2
Бараа материал	40,832.0	46,843.7	6,011.7
Үндсэн хөрөнгө	1,549,928.2	1,526,626.4	-23,301.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,590,760.3</b>	<b>1,580,113.4</b>	<b>-10,646.9</b>
Өр төлбөр	-	6,896.6	6,896.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	<b>1,590,760.3</b>	<b>1,573,216.8</b>	-17,543.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,590,760.3</b>	<b>1,580,113.4</b>	<b>-10,646.9</b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 6,643.2 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 46,843.7 мянган төгрөг болж 6,011.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 96,609.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр 323.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материал дансанд бүртгэж, 90,921.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,526,626.4 мянган төгрөг болж 23,301.8 мянган төгрөгөөр буурсан нь Сэлэнгэ аймгийн орон нутгийн өмчийн газрын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 508 дугаар албан бичгээр үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны үнийг нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг сунгахыг зөвшөөрсний дагуу нийт 17,977.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хасалт хийж дахин үнэлэн 17,026.7 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийг бүртгэж, тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардлын 47,535.9 мянган төгрөгтэй холбоотой байна.

Тайлант оны эцэст цэвэр бохир усны шугам хагарч эвдрэл гэмтэл гарснаас шалтгаалан цэвэр бохир усны 6,896.6 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,573,216.8 мянган төгрөг болж 17,543.5 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 417,111.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 174,330.6

мянган төгрөг, нийт зардлыг 591,442.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн тооцоололд МУЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 107 тоот тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ хэмжээ”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/122 тоот тушаал “Төрийн орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээ”-г тус тус шинэчлэн тогтоосны дагуу багш, ажилчдын цалинг нэмэгдүүлэн тооцсон байна.

Төсвийн төслийн саналаас 90,882.5 мянган төгрөгөөр өсгөж 682,324.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд, цалин хөлсний зардлыг 39,512.8 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7,822.9 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 15,647.5 мянган төгрөгөөр, бараа, үйлчилгээний бусад зардлыг 12,371.9 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 7,320.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 17,607.7 мянган нэмэгдүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 682,324.9 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс 577,233.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 105,091.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 675,681.5 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2,924.0 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 2,829.3 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	67,090.0	67,089.9	0.1	99.9%
2	80112- Нийтлэг үйлчилгээ	38,001.6	38,001.4	0.2	99.9%
3	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,700.0	1,375.0	325.0	80.8%
4	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	79,512.9	76,588.9	2,924.0	96.3%
5	81816- Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1,882.8	1,882.8	-	100%
6	81823- Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,700.0	1,700.0	-	100%
7	81834- Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	383,320.2	380,490.9	2,829.3	99.2%
8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	109,117.4	108,552.6	564.8	99.4%
	<b>Нийт дүн</b>	<b>682,324.9</b>	<b>675,681.5</b>	<b>6,643.4</b>	<b>99.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор Ц.Сувдаа гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Ш.Ичинхорлоо, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 6 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс Ауди”-т ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 551,458.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,514.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог

хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Мандал сумын 2дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор ажил олгогчоос төлөх НДШ, үдийн цай хөтөлбөр, бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 6,643.4 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 133 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,837.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 21,028.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,550.1 мянган төгрөгийн 3 залруулга хийж, 1 албан шаардлага, 19,478.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн боловч бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулалгүйгээр зөрчлийг давтан гаргаж зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	19,478.3			
Албан шаардлага	1	0.0	1	0.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>19,478.3</b>	<b>1</b>		<b>50%</b>

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхааран авч үзэх нь зүйтэй. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлийг үүсгэж байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны

онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 1,012.5 мянган төгрөгийн зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлээ.

### **5.1 Албан шаардлага**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 1,012.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	1,012.5			1	1,012.5						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,012.5</b>			<b>1</b>	<b>1,012.5</b>						